



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 05 сарын 09 өдөр

Дугаар

5/19

Модот

**“Иргэдийн спортын их наадам”
арга хэмжээнд оролцох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Биеийн тамир спортын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, 15.1.3, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь


1. Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын салбарын хөгжлийг бүсийн онцлог байдалтай уялдуулах, нэгдсэн удирдамжаар хангах, мэргэжлийн дэмжлэг үзүүлэх зорилгоор зохион байгуулж буй Хэнтий аймгийн баруун бүсийн “Иргэдийн спортын их наадам”-д иргэдээс баг бүрдүүлж оролцуулсугай.

2. Уг тэмцээний тусгай удирдамжийн дагуу баг тамирчдын бэлтгэл бэлэн байдлыг хангаж ажиллахыг Нийгмийн бодлогын түшмэл (И. Найманцэцэг)-т даалгасугай.

3. Дээрх арга хэмжээнд шаардагдах зардлыг Засаг даргын нөөц хөрөнгөөс 1,900,000 (Нэг сая есөн зуун мянган төгрөг)-ийг тооцож гаргахыг Санхүү албаны нягтлан бодогч (Б. Буяндэлгэр)-т зөвшөөрсүгэй.

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч дарга (Б. Ганзориг) -д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А. МӨНХ-ОРГИЛ